



**“БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ БАТЛАХ ТУХАЙ”
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл:

Монгол Улсын Их Хурлаас 2003 онд баталсан Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтад заасны дагуу Монгол Улсын Их Хурал нь Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг батлах бүрэн эрхтэй байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3 дугаар бүлгийн 3.7.4-т “Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс нутгийн оновчтой бүтэц, хөгжлийн ирээдүйтэй сууриныг тодорхойлж, агаарын тээвэр, авто зам, төмөр замын сүлжээнд холбоно.” гэж, 6 дугаар бүлгийн 6.2.2-т “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулж, эдийн засгийн төрөлжилт, дагналт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдэх суурь нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 3 дугаар бүлгийн 3.6.6-д “хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс нутгийн оновчтой бүтэц, хөгжлийн ирээдүйтэй сууриныг тодорхойлж, орон зайн төлөвлөлтийг хийнэ.” гэж заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Монгол Улсыг Бүсчлэн хөгжүүлэх бодлогыг тодорхойлох арга хэмжээний тухай” 07 дугаар тогтоолын 2.2 дахь хэсэгт Бүсчилсэн хөгжлийн бодлогыг боловсронгуй болгохыг Засгийн газарт даалгасан болно.

Практик шаардлага:

“Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг 2001 онд Улсын Их хурлын 57 дугаар тогтоолоор батлан мөрдүүлснээс хойш 23 жилийн хугацаа өнгөрч байна.

Тус үзэл баримтлалаар газар түүний баялаг, түүхий эдийн нөөц, оюуны чадавхыг оновчтой ашиглан хүн ам, үйлдвэрлэлийн зохисгүй бөөгнөрлийг задалж, хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа, алслалт, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө аймаг, бүс нутаг хоорондын тэнцвэргүй байдлыг багасган хөгжлийн түвшнийг ойртуулж, эдийн засаг, нийгмийн дэвшлийг түргэтгэх эрхэм зорилгыг дэвшүүлсэн. Энэ хүрээнд Баруун, Хангайн, Төвийн, Зүүн, Улаанбаатарын гэсэн эдийн засгийн таван бүсийн тогтолцоонд шилжүүлсэн.

Тухайн таван бүсээр “Бүсүүдийн хөгжлийн хөтөлбөр”-ийг 2006 онд Засгийн газар батлан, дэд бүтэц, уул уурхай, аялал жуулчлал, хөдөө аж ахуй, хөнгөн, хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга хэмжээг тухай бүр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон салбаруудын бодлогын баримт бичгүүдэд тусган хэрэгжүүлж ирсэн.

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ын хэрэгжилтийг 2023 оны байдлаар 45.5 хувь буюу “хангалтгүй” гэж үнэлсэн болно.

Энэ хугацаанд Нийслэл Улаанбаатар хотод нийт хүн амын 48.9 хувь буюу 1.7 сая хүн амьдарч, бүртгэлтэй аж ахуйн нэгжийн 70 хувь, худалдаа үйлчилгээний 84 хувь, их дээд сургуулийн 96 хувь нь төвлөрч, ДНБ-ний 63 хувь нь үйлдвэрлэгдэж байгаа нь хот, хөдөөгийн хөгжлийн ялгаатай байдал үүссэнийг харуулж байна.

Мөн иргэд чанартай боловсрол, нийгэм, соёлын олон төрлийн үйлчилгээ, эдийн засаг, санхүүгийн боломжийг эрэлхийлэн хот, суурин газрыг чиглэсэн шилжилт хөдөлгөөн хийснээр хөдөө, орон нутагт ажиллах хүчин хомсдож, эдийн засаг, хөгжлийн тэнцвэргүй байдал үүсэж нийслэл хотод авто замын түгжрэл, агаар, хөрсний бохирдол, нийгмийн үйлчилгээний хүртээмжгүй байдал бий болоод байна.

Өнгөрсөн 23 жилийн хугацаанд Улсын Их Хурлын сонгуулийн тойрог аймаг, дүүргээр байсан нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, хөтөлбөрүүдийг аймаг, сум, дүүрэгт зориулан хэт жижиглэн хуваарилах нөхцөлийг бүрдүүлж байсан. Энэ нь бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд туссан үндэсний, бүс дамнасан стратегийн ач холбогдол бүхий бүтээн байгуулалтын төслүүдийн хэрэгжилт удаашрах үндсэн шалтгаан болсон.

Иймд дээр дурдсан үндэслэл, шаардлагыг харгалзан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, батлуулах шаардлагатай байна.

Хоёр.Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь 4 хэсэгтэй. Үүнд:

1 дэх хэсэгт Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг нэгдүгээр хавсралтаар, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин"-г хоёрдугаар хавсралтаар батлах тухай;

2 дахь хэсэгт тогтоол батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний талаар Засгийн газарт даалгах тухай;

3 дахь хэсэгт тогтоол хүчин төгөлдөр болох хугацаа;

4 дэх хэсэг Энэ тогтоол гарсантай холбогдуулан Улсын Их хурлын 2001 оны "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай" 57 дугаар тогтоол, Улсын Их Хурлын 2003 оны "Бүсийн тулгуур төв хотыг тогтоох тухай" 1 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцох тухай.

Гурав.Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засгийн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Тогтоолын төсөл батлагдсанаар Монгол Улсыг нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд Хангайн, Баруун, Хойд, Төвийн, Зүүн, Говийн, Улаанбаатарын гэсэн долоон бүс болгон хөгжүүлэх төлөвлөлт, хэрэгжилт, бүс нутгийн хөгжлийг дэмжих дэмжлэгийн хэлбэр, механизмыг бүрдүүлэх бодлого, эрх зүйн орчин бүрдэж, бүс орон нутгийн хөгжлийн түвшний ялгаа багасаж, эдийн засгийн өсөлт нэмэгдэнэ.

Бүс тус бүрийн "Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр"-ийг Монгол Улсын Их Хурлаар батлуулж, хэрэгжилтийг төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд иргэн, хуулийн этгээдийн оролцоог хангах замаар зохион байгуулна.

Дөрөв.Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай нийцэж байгаа бөгөөд тогтоолын төсөлтэй холбогдуулан боловсруулах хууль тогтоомжийн төсөл байхгүй болно.